



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

“ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ”

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ДҮНГЭЭС



ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН ТӨВЛӨРҮҮЛЭЛТ ХАНГАЛТГҮЙ
БАЙНА.

АУДИТЫН КОД: БӨА-2025/27-2-ШТА-ГА




“ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС

Төлөвлөгөө

2023 он

2024 он



Баян-Өлгий аймгийн 2023 оны орон нутгийн төсвийн суурь орлогын 5.6 хувийг буюу 1,160.1 сая төгрөгийг, 2024 оны орлогын 5.6 хувийг буюу 2,230.7 сая төгрөгийг торгуулийн орлогоос бүрдүүлэхээр төлөвлөж баталсан байна.

Торгуулийн орлогыг бодитой төлөвлөөгүйгээс 2023, 2024 онуудад тасарсан байна



Торгуулийн орлогын төлөвлөгөө нь өмнөх жилүүдэд биелэгдэж ирсэн боловч 2023 онд 185.9 сая төгрөгөөр, 2024 онд 1,055.1 сая төгрөгөөр тасарсан байна.

Торгуулийн орлогын үлдэгдэл, хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн байдал

сая төгрөгөөр

Он	Торгууль				Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн	Хууль хяналтын байгууллагаас хэрэгсэхгүй болгосон
	Зөрчлийн тоо	Ногдуулсан	Төлсөн	Үлдэгдэл		
2023 он	31061	1362.2	1158.5	203.7	17.4	10.0
2024 он	20452	1588.3	1233.2	355.1	195.0	30.0
Дүн	51513	2950.5	2391.7	558.8	212.4	40.0



“ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС



Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд аймгийн ИТХ-ын тогтоолоор 2023 онд 198.0 сая төгрөг, 2024 онд 185.3 сая төгрөгийг хуваарилж баталсан ба Ногооннуур, Сагсай, Толбо, Улаанхус, Цэнгэл, Өлгий сумууд 2023 онд нийт 38.0 сая төгрөг, 2024 онд 48.0 сая төгрөгийг хуваарилан баталсан байна. Алтай, Алтанцөгц, Баяннуур, Бугат, Булган, Буянт, Дэлүүн сумууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд төсөв хуваарилж батлаагүй, хуулиар заасан бүрэн эрхээ хэрэгжүүлээгүй байна

Цагдаагийн газрын бэлэн бус торгууль төлсөн хэлбэр

(сая төгрөгөөр)


Торгууль төлсөн хэлбэр	2023 он		2024 он		Нийт мөнгөн дүн
	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	
E-Mongolia	9476	196	5941	147.4	343.4
Ebarimt	65	1.3	3	0.06	1.36
Gerege	2779	68.3	1653	50.9	119.2
Smartcar	3627	75.8	1381	35.3	111.1
Банк	5031	122.7	3090	90.4	213.1
Бусад аппликейшн	146	3.5	77	3.1	6.6
Нийт дүн	21124	467.6	12145	327.16	794.76



“ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС



Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:



ЗӨВЛӨМЖ

Аймгийн ИТХ-ын дарга танаа:

Торгуулийн орлогыг төлөвлөлт, бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт хэрэгжүүлж ажиллах;

Аймгийн Засаг дарга танаа:

Торгуулийн орлогыг үндэслэлтэй төлөвлөж, бүрэн төвлөрүүлэх, он дамжсан авлагыг барагдуулах талаар эрх бүхий байгууллагуудад чиглэл өгч, хэрэгжилтийг хангуулах;

Сумуудад торгуулийн орлогоос гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хуваарилах зардлыг хуульд заасан хувь хэмжээгээр төлөвлөх талаар чиглэл өгч, хуулийн хэрэгжилтийг хангуулах;

Баян-Өлгий аймгийн Цагдаагийн газар, Байгаль орчны газар, Татварын газар-т:

Хууль, тогтоомжуудын хэрэгжилтийг ханган ажиллаж, торгуулийн орлогыг төсөвт бүрэн төвлөрүүлэх;

